



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1998 оны 5 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь технологи дамжуулах үйл ажиллагааны зарчим, технологийн түвшний үнэлгээ хийх, технологи дамжуулах үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тодорхойлж, технологи дамжуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Технологи дамжуулах тухай хууль тогтоомж

2.1. Технологи дамжуулах тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль¹ Патентын тухай хууль² болон энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. технологи гэж оюуны бүтээлийг хэрэглээний бүтээгдэхүүн болгон хувиргахад чиглэгдсэн хүн, техник, мэдээлэл, зохион байгуулалтын харилцан уялдаатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргуудын цогцыг;

3.1.2. технологи дамжуулах гэж технологи эзэмшигч өөрийн технологийг ашиглах эрхийг бусад иргэн, хуулийн этгээдэд гэрээний үндсэн дээр шилжүүлэх үйл ажиллагааны цогцолборыг;

3.1.3. технологийн горим гэж хүний тодорхой зорилго бүхий үйл ажиллагааг зохицуулан хэрэгжүүлэхэд чиглэгдсэн, шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон физик, хими, биологийн үйл явц болон хүний үйл ажиллагаанд суурилсан үйлдлүүдийн цогцолборыг;

3.1.4. "ноу-хау" гэж үйлдвэрлэл, удирдлага, худалдаа, санхүүгийн үнэ цэнэ бүхий бөгөөд хуулиар эрхийн хамгаалалт хийгдээгүй, нууцлагдсан, эзэмшиж ашиглахад тодорхой мэргэшил шаардагдах аливаа мэдлэг, туршлагыг.

4 дүгээр зүйл. Технологи дамжуулах үйл ажиллагааны зарчим

4.1. Технологи дамжуулах үйл ажиллагаанд дараахь зарчим баримтална:

4.1.1. технологи дамжуулах үйл ажиллагаа нь шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогод нийцсэн байх;

4.1.2. технологи дамжуулах үйл ажиллагаанд төрийн зохицуулалт, чөлөөт өрсөлдөөнийг хослуулах;

4.1.3. дамжуулах технологи нь байгаль орчин, хүний эрүүл мэнд, мал, амьтанд сөрөг нөлөөгүй байх;

4.1.4. техник, технологийн сүүлийн үеийн ололтыг ашиглахад чиглэгдсэн байх;

4.1.5. эдийн засгийн хөшүүргээр технологи дамжуулах үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх;

4.1.6. технологи дамжуулах үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага чөлөөтэй оролцох.

5 дугаар зүйл. Технологи дамжуулах талаархи Засгийн газрын бүрэн эрх

5.1. Технологи дамжуулах талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. технологи дамжуулах талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.1.2. төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын технологийн шинэчлэлийг эдийн засгийн баталгаагаар хангах;

5.1.3. технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогчид үзүүлэх урамшуулалт, хөнгөлөлт, тэдгээрийн хэлбэр, хэмжээг тогтоох;

5.1.4. хуульд заасан бусад бүрэн эрх.

6 дугаар зүйл. Технологи дамжуулах талаархи технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

6.1. Технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь технологи дамжуулахтай холбогдсон дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. технологи дамжуулах хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналт тавих, технологи дамжуулах үйл ажиллагааг шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлэх төрийн бодлоготой нийцүүлэн зохицуулах;

6.1.2. технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран эрх олгох, холбогдох дүрэм, журмыг боловсруулж мөрдүүлэх;

[/Энэ заалтад 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

6.1.3. технологи дамжуулахтай холбогдох мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;

6.1.4. тэргүүний технологи нэвтрүүлэх асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран төсөл зарлаж шалгаруулах, тэргүүний технологи ашиглах талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал, санаачилгыг дэмжих;

6.1.5. технологи эзэмшигчийн эрхийг хамгаалах асуудлыг зохицуулах;

6.1.6. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Технологийн түвшний үнэлгээ

7 дугаар зүйл. Технологийн түвшний үнэлгээ

7.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ашиглаж байгаа технологийнх нь улмаас хүний эрүүл мэнд, мал амьтан, байгаль орчинд хохирол учруулбал, эсхүл тухайн чиглэлийн технологи дамжуулахыг хянаж байхаар Засгийн газар хоорондын болон Монгол Улсын нэгдсэн бусад олон улсын гэрээ хэлэлцээрт заасан бол уг технологид төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан эрдэм шинжилгээний байгууллагаар үнэлгээ хийлгүүлнэ.

7.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь шинээр хэрэглэх технологийнхээ түвшинд 7.1-д заасан байгууллагаар үнэлгээ хийлгүүлж болно.

7.3. Эрх бүхий эрдэм шинжилгээний байгууллага технологийн түвшинг үнэлэхдээ дараахь үзүүлэлтийг харгалзана:

7.3.1. технологийн техникийн үндсэн үзүүлэлтүүдийг ижил төрлийн технологийн харгалзах үзүүлэлтүүдтэй харьцуулан тогтоосон үнэлэлт;

7.3.2. технологийг ашигласнаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, мал, амьтан, үйлдвэрлэлийн нөхцөлд үзүүлж болох эерэг, сөрөг болзошгүй нөлөөлөл, сөрөг үр дагаврыг бууруулах зөвлөмж;

7.3.3. технологийг ашигласны эдийн засгийн үзүүлэлтүүд;

7.3.6. бүтээгдэхүүний стандарт, чанар, аюулгүй байдлын үзүүлэлт;

7.3.5. технологийг ашиглахад шаардагдах мэргэжилтний хүрэлцээ хангамж;

7.3.6. тухайн технологийн онцлогтой холбогдох бусад үзүүлэлт.

7.4. Технологийн түвшинг үнэлэх эрдэм шинжилгээний байгууллага нь үнэлгээ хийж байгаа технологийн нууцыг чандлан хадгалах үүрэгтэй бөгөөд хийсэн үнэлгээнийхээ талаар батламж гаргана.

7.5. Холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллага технологийн түвшингийн үнэлгээ хийхэд шаардагдах баримт бичиг, бусад зүйлийг саадгүй бүрдүүлж өгч, үнэлгээ хийлгэвэл зардлыг хариуцна.

7.6. Технологийн түвшний үнэлгээ хийсний дараа тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн технологийг цаашид ашиглахыг хориглох талаар шийдвэр гаргаж болно.

/Энэ хэсэгт 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

7.7. Технологийн түвшний үнэлгээ хийх журам, үнэлгээний хэмжээг тогтоох аргачлалыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

/Энэ хэсэгт 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Технологи дамжуулах

8 дугаар зүйл. Дамжуулах технологид хамаарах зүйл

8.1. Дамжуулах технологид дараахь зүйл хамаарна:

8.1.1. технологийн горим, үйл ажиллагааны нөхцөл;

8.1.2. технологийн шат дамжлагын дэс дараалал, горим, бүрдэл хэсгийн талаархи зөвлөгөө, үйлчилгээ;

8.1.3. технологи нэвтрүүлэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж;

8.1.4. шинжлэх ухаан, технологийн судалгаа шинжилгээний үр дүн;

8.1.5. патент, лиценз, бүтээгдэхүүний загвар;

8.1.6. ноу-хау.

9 дүгээр зүйл. Дамжуулах технологид тавих шаардлага

9.1. Дамжуулах технологи нь дараахь шаардлагын холбогдох үзүүлэлтийг хангасан байна:

9.1.1. Монгол Улсын болон олон улсын стандартын үзүүлэлт, шаардлагад нийцсэн байх;

9.1.2. эрчим хүч, материал, түүхий эд хэмнэх, бүтээгдэхүүний өртөг, зардлыг хямдруулах;

9.1.3. түүхий эдийг иж бүрэн боловсруулж хэрэглэх, хаягдалгүй технологи нэвтрүүлэх, хоёрдогч түүхий эдийг дахин боловсруулж ашиглах боломжийг бий болгох;

9.1.4. үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн нь байгаль орчин, хүний эрүүл мэнд, мал амьтанд сөрөг нөлөөгүй байх;

9.1.5. дамжуулж байгаа технологийг хэрэгжүүлэх тодорхой үе шат бүрт шаардагдах хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг үндэслэлтэй тодорхойлсон байх;

9.1.6. хүн, техник, мэдээлэл, зохион байгуулалтын зэрэг технологийн бүрдэл хэсгүүдийн харьцааг оновчтой тогтоох, тэдгээрийг цаашид боловсронгуй болгох нөхцөл, боломжийг харгалзах.

10 дугаар зүйл. Дамжуулахыг хориглох технологи

Байгаль орчин, хүнд үзүүлэх нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс илүү сөрөг нөлөө үзүүлэхүйц технологийг дамжуулахыг хориглоно.

11 дүгээр зүйл. Технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогчийн эрх

11.1. Технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогч дараахь эрх эдэлнэ:

11.1.1. хууль тогтоомжоор хориглосноос бусад технологи дамжуулах үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх;

11.1.2. технологи дамжуулахтай холбогдсон мэдээлэл авах;

11.1.3. технологи дамжуулах үйл ажиллагааны хүрээнд зуучлах, бусдаар зуучлуулах;

11.1.4. дотоод, гадаадын болон олон улсын байгууллага, иргэнтэй хамтран ажиллах, туршлага солилцох, уулзалт, семинар, хурал зохион байгуулах.

12 дугаар зүйл. Технологи дамжуулах гэрээ

12.1. Технологи дамжуулах үйл ажиллагааг лицензийн гэрээгээр хэрэгжүүлнэ.

12.2. Технологи дамжуулах гэрээнд дараахь асуудлыг тусгана:

12.2.1. үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаатай холбогдсон ноу-хау болон нийлүүлэх бараа материал, түүхий эд, үйлчилгээний хүрээ, хэмжээ;

12.2.2. патент, барааны тэмдгийг ашиглах нөхцөл;

12.2.3. технологийг ашиглах, боловсронгуй болгох, түүнтэй холбогдон үүсэх давуу эрхийн тухай асуудал;

12.2.4. мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах нөхцөл, энэ талаар харилцан хүлээх үүрэг;

12.2.5. технологи нийлүүлэх, тоног төхөөрөмж суурилуулах, хүлээлгэн өгөх, үйлчилгээ хийх нөхцөл;

12.2.6. технологи, тоног төхөөрөмж, тэдгээрийн үйлчилгээний баталгаат хугацааг нотолсон худалдагч талын батламж;

12.2.7. дамжуулж байгаа технологитой холбогдсон болон түүнийг боловсронгуй болгосон тухай мэдээллээр хангах асуудал;

12.2.8. гэрээнд заасан үүргийг биелүүлэх талаар талуудын хүлээх хариуцлага, учирсан хохирлыг нөхөн төлөх асуудал;

12.2.9. технологийн нууцыг хадгалах болзол, нөхцөл;

12.2.10. маргааныг шийдвэрлэх журам;

12.2.11. технологи худалдан авах үнэ, лицензийн төлбөр, төлөх нөхцөл, хэлбэр;

12.2.12. дамжуулсан технологиор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах болон үйлчилгээ явуулах газар нутаг;

12.2.13. гэрээний хүчин төгөлдөр байх хугацаа.

12.2.14. бусад.

12.3. Технологийн нууцыг чандлан хадгалах үүргийг талууд харилцан хүлээж, учирсан хохирлыг хэрхэхийг гэрээнд тодорхой заана.

13 дугаар зүйл. Технологи дамжуулах гэрээнд хязгаарлалт тавихыг хориглох

13.1. Талууд технологи дамжуулах гэрээ байгуулахдаа дараахь харилцааны талаар хязгаарлалт харилцан тавихыг хориглоно:

13.1.1. технологийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг гуравдагч этгээдэд экспортлох;

13.1.2. бүтээгдэхүүний тоо хэмжээг тогтоох, үйлдвэрлэлийн технологийг өөрчлөх;

13.1.3. гуравдагч орноос өрсөлдөх чадвартай тэргүүний технологи авах;

13.1.4. технологи дамжуулагч тал үүргээ биелүүлэх боломжгүй болсон нь батлагдсан нөхцөлд бусад байгууллагаас материал, түүхий эд, тоног төхөөрөмж, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах;

13.1.5. гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээний хугацаа дууссаны дараа технологийг чөлөөтэй ашиглах.

14 дүгээр зүйл. Технологи дамжуулах гэрээг бүртгүүлэх

14.1. Технологи дамжуулах гэрээг оюуны өмчийн асуудал эрхэлсэн байгууллагад бүртгүүлнэ.

14.2. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн байгууллага нь олон улсын буюу Монгол Улсын стандартын шаардлагад нийцээгүй технологийг гадаад орноос оруулах, шинээр хэрэглэх тухай гэрээг бүртгэхдээ дараахь үнэлгээ, дүгнэлтийн аль нэгийг үндэс болгоно:

14.2.1. хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдлын талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт;

14.2.2. мал эмнэлэг, үржил, ургамал, газар тариалангийн үйлдвэрлэлийн технологи дамжуулж байгаа тохиолдолд хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт;

14.2.3. энэ зүйлийн 14.2.1, 14.2.2-т зааснаас бусад тохиолдолд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ.

14.3. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн байгууллага нь 14.2-т заасан дүгнэлтийг үндэслэн гэрээг бүртгэхгүй байж болно.

14.4. Технологи дамжуулах гэрээг бүртгээгүй тохиолдолд технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн технологийг ашиглахыг хориглох талаар шийдвэр гаргана.

15 дугаар зүйл. Лицензийн төлбөр

15.1. Технологи ашиглахаар авч буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн технологи эзэмшигчид төлөх төлбөрийг лицензийн төлбөр гэнэ.

15.2. Лицензийн төлбөр нь нэг удаагийн, эсхүл тухайн технологи ашигласнаас олох ашгийн тодорхой хувь хэмжээгээр тогтоосон байнгын шимтгэл, эсхүл эдгээрийг хосолсон хэлбэртэй байж болно.

15.3. Технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогч талууд лицензийн төлбөрийн хэмжээ, хэлбэр, хугацааг гэрээгээр харилцан тохиролцоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

16 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

Монгол Улсын болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хооронд үүссэн технологи дамжуулахтай холбогдсон маргааныг Монгол Улсын олон улсын гэрээ, талуудын хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын шүүх шийдвэрлэнэ.

17 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

17.1. Технологи дамжуулах тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зохих хууль тогтоомжийн дагуу эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэж, түүгээр хохирлыг арилгуулах, нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

17.2. Технологийн нууцыг задруулсан иргэнийг 50000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 60000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж байгууллагыг 250000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэлийг шүүгч ногдуулж, технологи эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

17.3. Технологийн түвшний үнэлгээ хийхэд шаардагдах баримт бичиг, бусад зүйлийг бүрдүүлж өгөөгүй, эсхүл энэ хуулийн 14.1-д заасны дагуу технологи дамжуулах гэрээг бүртгүүлээгүй иргэнийг 20000 - 50000 төгрөгөөр, албан тушаалтныг 30000 - 60000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000- 250000 төгрөгөөр торгох шийтгэлийг шүүгч ногдуулна.

17 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

17.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

17.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

[/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулахаар заасан бөгөөд үүнийг 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/](#)

18 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1998 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ
